



СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Үндэсний стандарт шинээр болон
шинэчлэн батлах, хүчингүй болгох тухай

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.2, 6.3, 6.5, 6.6, 20.2.1 дэх заалт болон Эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн стандартчиллын техникийн хорооны санал, дүгнэлт, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:


1. Нэгдүгээр хавсралтад заасан 7 нэрийн стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинээр баталсугай.
2. Хоёрдугаар хавсралтад заасан 4 нэрийн стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинэчлэн баталсугай.
3. Шинэчлэн баталсан стандарттай холбогдуулан гуравдугаар хавсралтад дурьдсан 7 нэрийн стандартыг холбогдох заалтын хамт хүчингүйд тооцсугай.
4. Шинээр болон шинэчлэн баталсан үндэсний стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэйд тооцсугай.
5. Стандартыг сурталчилах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн яаманд зөвлөмжилсүгэй.



ДАРГА

Г. ГАНТОМОР

Стандартчиллын үндэсний зөвлөлийн
2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
34 дүгээр тогтоолын 3.1 дүгээр хавсралт



**Шинээр баталсан
үндэсний стандартын жагсаалт**

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Эрхзүйн хэм хэмжээ
1.	Клиникийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 6673:2017	Заавал мөрдөх
2.	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 6674:2017	Заавал мөрдөх
3.	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 6675:2017	Заавал мөрдөх
4.	Эмгэг судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 6676:2017	Заавал мөрдөх
5.	Глауком өвчний оношлогоо, эмчилгээ	MNS 6677:2017	Заавал мөрдөх
6.	Ургамал, байгалийн гаралтай эмийн түүхий эд, тэдгээрээс бэлдсэн эм, биологийн идэвхит бүтээгдэхүүнд ялтсан хромоген тэжээлт орчин ашиглан нян хөгц мөөгөнцөр тодорхойлох түргэвчилсэн арга	MNS 6678:2017	Сонгон хэрэглэх
7.	Биологийн идэвхт бүтээгдэхүүн. Маалингийн тос. "Алтайн Омега-3, 6, 9" Техникийн ерөнхий шаардлага	MNS 6679:2017	Заавал мөрдөх


Стандартчиллын үндэсний зөвлөлийн
2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
34 дүгээр тогтоолын 1.4 дугаар хавсралт



Шинэчлэн баталсан
үндэсний стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Эрхзүйн хэм хэмжээ
1.	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5292:2017	Заавал мөрдөх
2.	Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5095:2017	Заавал мөрдөх
3.	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 6330:2017	Заавал мөрдөх
4.	Хамрын таславч тэгшлэх мэс засал	MNS 5357:2017	Заавал мөрдөх

Стандартчиллын үндэсний зөвлөлийн
2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
34 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт



**Хүчингүй болсон
үндэсний стандартын жагсаалт**

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Хүчингүй болгох шийдвэр заалт
1.	Хамрын таславч тайрах мэс засал	MNS 5357:2004	СХҮТ-ийн Зөвлөлийн 2004 оны 113-р тогтоолын 2-р хавсралтын 14 дэх заалт
2.	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5292:2011	СҮЗ-ийн 2011 оны 36-р тогтоолын 1-р хавсралтын 1 дэх заалт
3.	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа. 1-р хэсэг Төв эмнэлэг	MNS 6330-1:2012	СҮЗ-ийн 2012 оны 22-р тогтоолын хавсралтын 11 дэх заалт
4.	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа. 2-р хэсэг Тусгай мэргэжлийн төв	MNS 6330-2:2012	СҮЗ-ийн 2012 оны 22-р тогтоолын хавсралтын 12 дахь заалт
5.	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа. 3-р хэсэг Тусгай мэргэжлийн өргүй төв	MNS 6330-3:2012	СҮЗ-ийн 2012 оны 22-р тогтоолын хавсралтын 13 дахь заалт
6.	Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа. 4-р хэсэг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	MNS 6330-4:2012	СҮЗ-ийн 2012 оны 22-р тогтоолын хавсралтын 14 дэх заалт
7.	Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5095:2013	СҮЗ-ийн 2013 оны 63-р тогтоолын 1-р хавсралтын 2 дахь заалт